



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 26 өдөр

Дугаар А/359

Есөнбулаг

Төлөөлөгчдийг хүлээн авч, хүндэтгэл үзүүлэхэд хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.9 заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5 дахь заалт, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2023 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 26 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Аймгийн гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, гадаадын хөрөнгө оруулалт татах зорилтын хүрээнд Бүгд Найрамдах Солонгос Улсын төлөөлөгчдийг хүлээн авч, хүндэтгэл үзүүлэхэд шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

2. Шаардагдах 6,535,600 (зургаан сая таван зуун гучин таван мянга зургаан зуу) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

3. Төлөөлөгчдийг хүлээн авч, хүндэтгэл үзүүлэх хөтөлбөрийг батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Г.Чинбат)-д үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын 2023 оны 06
дугаар сарын 16-ны өдрийн 959 дугаар
захирамжийн хавсралт

ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зардлын утга	Нийт үнэ
1	Хэвлэл мэдээллийн зардал	1,840,000
2	Сумд ажиллах зардал	1,500,000
3	Байршуулах хэрэгслийн зардал	2,373,600
4	Зочид буудлын зардал	822,000
	Дүн	6,535,600

__ооо__

